



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/188

Дэлгэрмөрөн

**Шар усны үерээс урьдчилан сэргийлэх
чиглэлээр авах зарим арга
хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Шадар сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан “Шар усны аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж, аймгийн Засаг даргын 2022 оны 3 дугаар сарын 28-ний өдрийн А/188 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цаг агаарын дулааралтай холбогдуулан нуур, цөөрмийн мөс эрчимтэй хайлах, мөсний нягтрал багасаж байгаа тул урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл 30 хоногийн хугацаанд Холбоо нуур, Дал нуур, Ховол, Ац, Уртын гол орчмоор нутагладаг айл өрхүүдэд мэдээ мэдээлэл, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)- д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

Zahiramj -2022 on

642201035